



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 0/189

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 61 дүгээр
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 368,000.49 /гурван зуун жаран найман мянган төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн 61-р цэцэрлэг /Д.Рагчаасүрэн/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасаж буй нийт 368,000.49 /гурван зуун жаран найман мянган төгрөг дөчин есөн мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий сурах бичгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн 61-р цэцэрлэг /Д.Рагчаасүрэн/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000475

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2020 оны 05 дугаар сарын 06 ны өдрийн
01/129... тоот тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн 61-р цэцэрлэг

төгрөгөөр

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	НБГ-ын санал	ЭБХХК-ын шийдвэр
Тавилга эд хогшил											
1	Номын багц	10	Багц	1	368,000.49	368,000.49	368,000.49	-	Ашиглах боломжгүй муудсан	актлах	устгах
Номын фондын дүн					368,000.49	368,000.49	368,000.49	-			
Нийт дүн						368,000.49	368,000.49	-			
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн											
Устгах хөрөнгийн дүн						368,000.49	368,000.49	-			